Н.Гэндэнжамцын нэрэмжит
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# *Томуу, томуу-төст өвчин, сэргийлэлт, эмнэлзүй, эмчилгээний удирдамж*

ЭХЭМҮТ. АЭЭСТ
Б.Ариунхишиг

## *Томуу, томуу-төст өвчин,сэргийлэлт,эмнэлзүй,эмчилгээний удирдамж*

| | |
|---|---|
| Хамгийн элбэг тохиолдох өвчин | - Томуу,томуу төст өвчин буюу АЗЦХӨ |
| Сэрүүн бүсийн орнуудад | - Жилд 6 удаа ТТӨ –д өртдөг |
| Далд,хөнгөн хэлбэр | - 20-40 % |
| Амбулоторийн тусламж | - 20-30 % |
| Анхдагч шалтгаан | - 90-95 % нь вирус |
| АЗЦХӨ | - 200 гаруй төрлийн вирус үүсгэдэг. |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

## *Томуу, томуу-төст өвчин*

**Томуу** : Амьсгалын замаар дамжин тархаж, бүх насны хүмүүсийг өвчлүүлдэг цочмог халдварт өвчин

**Өвчний эх уурхай** :
Өвчтэй хүн

**Нууц үе**:
1-5 хоног, дунджаар 48 цаг

**Халдвартай үе**:
Өвчний нууц үеийн сүүлч, эмнэлзүйн шинж тэмдэг илэрснээс хойш эхний 3-5 хоногт хамгийн их халдвартай. Хүүхдэд 7 хоног байж болно.

**Улиралчлал**:
10- 4 сард өвчлөл ихэснэ.

**Халдвар дамжих зам**:
Агаар дусал, ахуйн хавьтал
/ Ханиаж, найтаахад вирус агаарт 7 метр зайд цацагдаж
1 найтаалтаар 40,000-аас илүү дусал агаарт тархдаг /

**Дархлаа:**
Халдвар үүсгэсэн “ тухайн вирус”-ийн л эсрэг өвөрмөц дархлаа үүсдэг. Эсрэгтөрөгчийн өөрчлөлтөнд орсон вирусээс хуучин дархлаа нь хамгаалахгүй

## Эмгэг жам

Томуугийн вирус АЗ-н салст бүрхэвчийн сормуусt хучуур эсэд нэвтэрч тэнд түргэн үрждэг. Тэгснээр тэнд сөнөрөл, үхжил, гуужилт явагдана.

Хучуур эсээс гадна цулцангийн эс, хундган эс, цулцангийн макрофагийг гэмтээж болно.

Вирүс ба эдийн задралын бүтээгдэхүүнүүд гэмтсэн хучуур эсийн хоригийг нэвтэрч , цусны гүйдэлд орон ерөнхий хордлогын үйлчилгээ үзүүлнэ.

Бичил эргэлт хямарснаас янз бүрийн ЭТ-нд цус эргэлт доголдсоноос болж тархи, бөөрний дээд булчирхай, уушиг, зүрх, ХГЗ гэмтэхэд хүргэж олон эрхтний дутагдал үүсгэж болно.

Вирус судасны хананд хорт нөлөө үзүүлэн судасны эндотель хөөж , нэвчимхий байдал нь ихэсч хаван, цус харвалт үүсэхээс гадна дотор эрхтнүүдэд цус дүүрч цусархаг болно.

Вирусийн хорт үйлчлэл ялангуяа ТМТ, ВМТ-г гэмтээнэ.

Ийнхүү вирус АЗ-н хучуур эдийн хамгаалалтыг алдагдуулж, хэсэг газрын ба ерөнхий дархлааг доройтуулснаас нянгийн 2догч халдвар хөгжинэ.

Томуугаар өвчилсний дараа зөвхөн халдвар үүсгэсэн “тухайн вирус”-ийн л эсрэг өвөрмөц дархлаа үүсдэг. Эсрэгтөрөгчийн өөрчлөлтөнд орсон вирусээс хуучин дархлаа нь хамгаалахгүй.

**2022-2023 оны**
**ЭХЭМҮТ-АЭЭСТ хийсэн томуугийн судалгааны дүнгээс:**

| Үзүүлэлт | | Тоо | Хувь |
|---|---|---|---|
| **Хүйс** | | | |
| | Эр | 102 | 54 |
| | Эм | 82 | 43.4 |
| **Нас** | | | |
| | 0-6 Сар | 53 | 28 |
| | 7сараас-2 нас | 88 | 46.6 |
| | 3-5 нас | 22 | 11.6 |
| | 6-13 нас | 17 | 9 |
| | 14-өөс дээш нас | 5 | 2.6 |
| **Хатгаагаар_өвдөж_байсан_эсэх** | | | |
| | Үгүй | 75 | 39.7 |
| | Тийм | 109 | 57.7 |
| **Томуугийн_вакцин_хийлгэсэн_эсэх** | | | |
| | Үгүй | 162 | 85.7 |
| | Тийм | 3 | 1.6 |
| **Хүндрэл илэрсэн** | | | |
| | Үгүй | 124 | 65.6 |
| | Тийм | 16 | 8.5 |
| **Эрчимт эмчилгээ** | | | |
| | Үгүй | 118 | 62.4 |
| | Тийм | 23 | 12.2 |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ

| | | Томуу А | | Томуу Б | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **Хүйс** | | | | | |
| | Эр | 7 | 50.00% | 15 | 62.50% |
| | эм | 7 | 50.00% | 9 | 37.50% |
| **Нас** | | | | | |
| | 0-6 Сар | 0 | 0.00% | 4 | 16.70% |
| | 7сараас-2 нас | 7 | 50.00% | 13 | 54.20% |
| | 3-5 нас | 4 | 28.60% | 1 | 4.20% |
| | 6-13 нас | 2 | 14.30% | 4 | 16.70% |
| | 14-өөс дээш нас | 1 | 7.10% | 2 | 8.30% |
| **Хаана амьдардаг** | | | | | |
| | гэр | 1 | 7.70% | 7 | 29.20% |
| | хашаа_байшин | 2 | 15.40% | 3 | 12.50% |
| | орон_сууц | 10 | 76.90% | 14 | 58.30% |
| **Халдварт өртсөн газар** | | | | | |
| | цэцэрлэг | 1 | 7.70% | 1 | 4.20% |
| | сургууль | 1 | 7.70% | 3 | 12.50% |
| | гэртээ | 3 | 23.10% | 7 | 29.20% |
| | мэдэхгүй | 8 | 61.50% | 11 | 45.80% |
| | бусад | 0 | 0.00% | 2 | 8.30% |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ

| | Томуу А | | Томуу Б | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Ханиалга | 12 | 85.70% | 23 | 95.80% |
| Халуурралт | 13 | 92.90% | 22 | 91.70% |
| Нус гоожих, хамар битүүрэх | 8 | 57.10% | 14 | 58.30% |
| Тамирдах унтамхай болох | 6 | 42.90% | 11 | 45.80% |
| Суулгах | 4 | 28.60% | 5 | 20.80% |
| Хоолой өвдөх | 3 | 21.40% | 7 | 29.20% |
| Толгой өвдөх | 2 | 14.30% | 5 | 20.80% |
| Таталт өгч байгаа эсэх | 2 | 14.30% | 5 | 20.80% |
| Цээжээр өвдөх | 3 | 21.40% | 3 | 13.00% |
| Бөөлжих | 2 | 15.40% | 3 | 12.50% |
| Шингэн алдалттай | 2 | 14.30% | 3 | 12.50% |
| Хөхрөлт | 1 | 7.10% | 2 | 8.30% |
| Чихний үрэвсэл | 0 | 0.00% | 2 | 8.30% |
| Арьсны тууралт | 0 | 0.00% | 1 | 4.20% |
| Булчингаар өвдөх | 0 | 0.00% | 1 | 4.20% |
| Нүдний салсын үрэвсэл | 0 | 0.00% | 0 | 0.00% |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ







| Үүсгэгч | Дундаж долоо хоног |
|---|---|
| томуу А | 30-Jan-23 |
| Томуу Б | 15-Feb-23 |
| RSV | 29-Jan-23 |
| Илрээгүй | 5-Feb-23 |

Амьсгалын замын вирусын шалтгаант цочмог халдварт өвчин Томуу ба Томуу төст өвчин бүлэгт хуваагдана.

# 1. Томуу гэж юу вэ?



### Томуу нь вирусээр үүсгэгддэг, амьсгалын цочмог халдвар:

А (хэвшинжийн вирус нь 1933 онд Y.Smith, K.Andrews нар нээсэн, маш хувьсамтгай, тахиа, шувуу, гахай, морь, нохой зэрэг амьтдад өвчин үүсгэх ба амьтнаас хүнд халдварлан улмаар томуугийн халдвар үүсгэх чадвартай.

H - Hemagglutinin 18 дэд хэв шинж

N - Neuraminidase 11 дэд хэв шинж

Жнь: Influenza A virus subtype H1N1, H1N2, H2N2 H2N3, H3N1, H3N2, H3N8, H5N1, H5N2, H5N3, H5N6, H5N8, H5N9, H6N1, H6N2, H7N1, H7N2, H7N3, H7N4, H7N7, H7N9, H9N2, H10N7, H18N11

В ( хэв шинжийн вирус 1940 онд T.Francis, T.Magill нар нээсэн. Улирлын томуугийн дэгдэлтийн үндсэн шалтгааны нэг болж байдаг, А хүрээний вирусыг бодвол хувьсан өөрчлөгдөх шинж чанар 2-3 дахин удаан, мутацад орох буюу генетикийн өөрчлөлт багатай )

С ( хэв шинжийн вирус 1947 онд P.Taylor нээсэн. Хүн, нохой, гахай халдварлуулах боловч бусад төрлүүдийг бодвол хөнгөн өвчлүүлдэг ) хүрээний 3 төрөл байна.

## *Томуу - Инфлюэнц - Influenza*

Амьсгалын замаар дамжин тархаж, бүх насны хүмүүсийг өвчлүүлдэг цочмог халдварт өвчин

| Өвчний эх уурхай | Өвчтэй хүн |
|---|---|
| Нууц үе | 1-5 хоног, дунджаар 48 цаг |
| Халдвартай үе | Өвчний нууц үеийн сүүлч, эмнэлзүйн шинж тэмдэг илэрснээс хойш эхний 3-5 хоногт хамгийн их халдвартай. Хүүхдэд 7 хоног байж болно. |
| Улиралчлал | 10-4 сард өвчлөл ихэснэ. |
| Халдвар дамжих зам | Агаар дусал, ахуйн хавьтал |
| Дархлаа | Халдвар үүсгэсэн “тухайн вирус”-ийн л эсрэг өвөрмөц дархлаа үүсдэг. Эсрэгтөрөгчийн өөрчлөлтөнд орсон вирусээс хуучин дархлаа нь хамгаалахгүй |
| Өртөмтхий бүлэг | Нялхас, бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настан, архаг хууч өвчтэй хүмүүс |

## Халдварлах зам

**Өвчний эх уурхай:**
өвчтэй хүн

**Халдварлах зам:**
агаар дусал, ахуйн хавьтал

*/ Ханиаж, найтаахад вирус агаарт 7метр зайд цацагдаж 1 найтаалтаар 40,000-аас илүү дусал агаарт тархдаг /*




## Эрсдэлт бүлэг

- 0-5 хүртлэх насны хүүхдүүд :
  - жил бүр 20.000 хүүхэд томуугийн хүндрэлээр хэвтэн эмчлүүлдэг.
  - 0-2 насны хүүхдүүдийн дунд томуугийн хүндрэлийн эрсдэл хамгийн өндөр
  - вакцинжуулалтыг 6 сараас доош насны хүүхдэд зөвшөөрдөггүй тул тэдний̆г хамгаалах хамгийн сайн арга бол бүх өрхийн гишүүд болон асран халамжлагчдыг вакцинжуулах явдал юм.
- 65-аас дээш өндөр настангууд:
  - 65 ба түүнээс дээш насны хүмүүс томуугийн вакцинд хариу өгөх чадавхи багасч
  - ханиадтай холбоотой нас баралтын 90%
  - ханиадтай холбоотой эмнэлэгт хэвтэх өвчний 60% эзэлж байна
- Жирэмсэн болон төрөөд удаагүй байгаа эмэгтэйчүүд
- Дархлаа сул хүмүүс:
  - ХДХВ-н халдвартай, химийн эмчилгээ хийлгэж байгаа, удаан хугацаагаар стеройд хэрэглэдэг
- Архаг хууч өвчтэй хүмүүс:
  - элэг, бөөр, зүрх, астма, чихрийн шижин эмгэгтэй
- Биеийн жингийн илүүдэлтэй хүмүүс:
  - биеийн жингийн индекс >40
- **Эрүүл мэндийн ажилтанууд** нь өөрсдөө халдвар авах өндөр эрсдэлтэйгээс гадна бусдад тараах эрсдэлтэй **онцгой бүлэгт хамаарна**.

## Томуугийн үеийн шинж тэмдэг

Ханиалга нь хүндэрч, 2 ба  түүнээс дээш долоо хоног үргэлжилж болно.

Ихэнх хүмүүс 7 хоногийн дотор халууралт ба бусад шинж тэмдгүүд эдгэрч хөнгөн хэлбэрээр өвчилдөг.

Томуу нь ялангуяа өндөр эрсдэлтэй хүмүүст хүнд хэлбэрээр өвчилж үхэлд хүргэж болзошгүй аюултай.




## Томуугийн үеийн аюултай шинжүүд:

### Хүүхэд

- Өндөр халуурах (38С дээш)
- Амьсгалын тоо ихсэх
- Уруул, нүүр хөхрөх
- Цээж хонхолзох
- Цээжээр өвдөх
- Булчин өвдөх:  - *хүүхэд алхах дургүй байх*
- Шингэн алдах:  - 8-аас дээш цаг шээхгүй
  - ам хатах
  - уйлахад нулимсгүй
- Халуурах
- Ханиалгах зовиур олон хоног үргэлжлэх

### Насанд хүрэгчид

- Амьсгал давчдах
- Цээж, хэвлийгээр байнгын өвдөлт
- Даралт өөрчлөгдөх
- Толгой эргэх
- Шээсний гарц буурах
- Гэдэсний булчингийн өвдөлт
- Ядрах, идэвхигүй болох
- Халуурах, ханиалгах зовиур улам ихсэх
- Архаг хууч өвчин сэдрэх

# Эмнэлзүйн үндсэн хэлбэрүүд

1. Амьсгалын дээд замын, халууралтгүй, хөнгөн хэлбэр:
- ТТТӨ-ний шинжүүд/ Халуурах, Ханиалгах, хоолой сөөх, хамраас нус гоожих, толгой өвдөх, булчингаар өвдөх, бие сулбайх/
- Амьсгал богиносох болон хүчлэн амьсгалах шинж илрэхгүй
- Ходоод гэдэсний хямрал /усгүйжилтийн шинжгүй /

2. Халууралттай томуу, томуу төст өвчин

3. Хүнд ба хүндрэлтэй томуу:
   - Түргэн даамжрах явцтай уушгины үрэвсэл, АЦДХШ, ужил, ОЭД
   - Бусад хүндрэл: нянгийн хоёрдогч халдвар, бөөрний дутмагшил, миокардит, энцефалит, амьсгалын замын архаг өвчин сэдрэх, үгдрэх
   - Нугасны шингэн өөрчлөлтгүй байдаг.

## Өвчин үгдрэн даамжирч байгааг илтгэх шинжүүд:

- Хүчилтөрөгчийн хангамж муудах, зүрх-уушгины дутмагшлын шинжүүд:
  - ✓Амьсгал богиносох
  - ✓Амьсгалахад саадтай болох
  - ✓Хөхрөх
  - ✓Цустай цэр гарах
  - ✓Цээж өвдөх
  - ✓Даралт багасах
- ТМТ-ы хүндрэлийн шинжүүд:
  - ✓Ухаан бүдэг болох
  - ✓Ухаан алдах
  - ✓Толгой эргэх
  - ✓Сэрэхгүй унтаарах
  - ✓Татах
  - ✓Булчин сулрах
  - ✓Саа саажил
- Вирусын үржил халдварлагдсан нянгийн хоёрдогч халдварын шинж:
  - ✓3-с олон хоног халууралт үргэлжилнэ
- Хүнд усгүйжилт
  - ✓Шээсний гарц багасах

Параинфлюнза вирусын халдвар（Parainfluenza）/ Иж томуу/:

- Халдварын эх уурхай нь өвчтэй хүн

/жилийн турш идэвхитэй байх ба голлон хавар намрын улиралд 5 хүртэл насны хүүхэд өртөмтгий байна./

- Агаар дуслын замаар халдварлана.
- Далд үе – 2- 7 өдөр
- Вирус голдуу хамар, төвөнхийн хучуур эсэд үржин, тэнд бүтэц эвдрэлийн өөрчлөлт гарган үрэвсүүлснээс салст бүрхэвчинд үрэвслийн шүүдэс хуралдан салст хавагнадаг.
- Эмнэлзүйн хэлбэрүүд: АЦХ, төвөнхийн нарийсалт үрэвсэл, төвөнх-мөгөөрсөн хоолойн ба гуурсны үрэвсэл,
- Өвчин АЗ-н улайх үрэвслээр аажим эхэлнэ.
- Хордлогын шинж илрэхгүй буюу бие сулрах , толгой өвдөх байдлаар сул илэрнэ
- Халуурлалт өндөр биш, 4-7 өдөр үргэлжилнэ
- Хамрын амьсгал саадтай болж салслаг нус гоожиж ринитын шинжээр эхлэдэг
- Хөөмий бага зэрэг улайсан, харин төвөнх гэмтэх нь гол шинж
- Өвчний 90%-д төвөнхийн үрэвсэл / хоолой хөндүүрлэж сөөх, хуурай хуцуулж ханиалгах/ цаашлаад төвөнхийн нарийсал үүсдэг

## Томуу өвчний хүндрэл

| | Pneumonia | Nasopharyngitis | Otitis media | group A Streptococcal tonsillitis | Conjunctivitis | Enteritis |
|---|---|---|---|---|---|---|
| Influenza virus A+B types | 0.7 | 0.06 | 0.8 | 0.3 | 0.8 | 0.4 |
| Influenza virus A type | 0.9 | 0.1 | 0.7 | 0.5 | 0.9 | 0.6 |
| Influenza virus B type | 0.5 | 0.4 | 0.7 | 0.3 | 0.4 | 0.3 |

**influenza positive (N = 121)**

P value >0.05

Relationship of influenza virus infection to associated infections in children who present with influenza-like symptoms
Yitzchok M. Norowitz, Stephan Kohlhoff and Tamar A. Smith-Norowitz* Norowitz et al. BMC Infectious Diseases (2016) 16:304 DOI 10.1186/s12879-016-1642-8

## Дунд чихний цочмог үрэвсэл

Үүсгэгч: вирус+нян - 66%

бактер - 92%

вирус - 70%. Үүнээс:

41% риновирус, энтервирус

23% амьсгалын замын синцитиаль вирус

6%д инфлюэнза зэрэг вирусээр үүсгэгддэг.

*Халуурах*
*Чихээр хатгаж өвдөх*
*Хэнгэргэн хөндийд шингэн хурах*
*Сонсгол буурах*
*Аутопони*




# Хамар дайвар хөндийн үрэвсэл

Хамар дайвар хөндийн үрэвслийн 80%г Риновирусийн 100 гаруй хэв шинж, коронавирус, зэрэг вирусууд үүсгэнэ. Ихэвчлэн шинж тэмдгийн эмчилгээ хийх боловч насанд хүрэгчдийн 0,5-2%, хүүхдэд 5-13% нь нянгийн гаралтай хамар дайврын үрэвсэлд шилждэг.

Халуурах
Хамар битүүрэх
Нүүр, дух, хацар
чинэрч өвдөх
Үнэрлэхүй буурах
Хамраас ялгадас гарах



## Төвөнх, цагаан мөгөөрсөн хоолой үрэвсэл

Төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн цочмог үрэвслийн >80% томуу төст амьсгалын замын вирусууд үүсгэнэ. (аденовирус, респиратор-синцитиаль вирүс, коронавирус)

**Төвөнхийн цочмог үрэвсэл: (Acute laryngitis) - бачуурралт бүхий**

- Халуурах
- Хуцуулж ханиалгах
- Амьсгал авалт саадтай /ЭАЯТ- A.B /
- Хяхтнаа амьсгалтай / ХӨЦМ /
- Хоолой сөөх
- Амьсгал бачуурна / хоолой боох /

**Төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн үрэвсэл: (laryngotrachebronchitis-croup)**

- Халуурах (40С)
- Хуурай хуцуулж ханиалгах
- Хоолой сөөх
- Залгихад төвөгтэй-dysphagia
- Ярихад төвөгтэй-dysphonia
- Ядрах, бие сулрах
- Төвөнхийн салст хавагнах
- Атлектаз

## Залгиур, гүйлсэн булчирхайн үрэвсэл

Adenovirus (Судалгаагаар вирусын гаралтай цочмог фарингитын 88%-д цочмог тонзиллитын 53%-д аденовирусээр үүсгэгдэнэ)

Respiratory syncytial virus (Улирлын шалтгаант фаринго-тонзиллит нь 35.5%д амьсгалын замын синцитиаль вирусээр үүсгэгдэнэ)

Enterovirus (гар, хөл, амны өвчин, ходоод-гэдэсний хам шинж гэсэн хэлбэрээр хүүхдэд ихэвчлэн тохиолдоно)

*Халуурах*
*Хоолой өвдөх*
*Ам, залгиурт цусархаг, цэврүүт тууралт гарах*
*Энэ тууралт биеийн бусад хэсгээр гарах (гар, хөл)*



Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

## 2. Томуу төст өвчин гэж юу вэ ?




**Томуу төст өвчин** буюу ханиад шуухинааг үүсгэгч анхдагч шалтгааны 95% орчим нь вирүс бөгөөд 200 гаруй нэр төрлийн вирүс амьсгалын замын хамшинжээр илрэх өвчин үүсгэдэг байна.

| Амьсгалын замын цочмог халдварын байрших эд, эрхтэнүүд | Үүсгэгч вирүс | |
|---|---|---|
| | Ихэнх тохиолдолд | Зарим ховор тохиолдолд |
| Хамар, залгиурын үрэвсэл | Риновирүс (100 гаруй хэвшинжтэй), иж томуугийн вирүс (3 хэвшинжтэй), томуугийн вирүс (3 хэвшинжтэй), коронавирүс, RSV, энгийн херпес вирүс | Аденовирүс (35 хэвшинжтэй), коксаки вирүс (29 хэвшинжтэй) ECHO вирүс (32 хэвшинжтэй) Эпштейн-Баррын вирүс |
| Бахуулай вирүс (ларингит, трахеит) | Иж томуугийн вирүс (3 хэвшинжтэй), томуугийн вирүс (3 хэвшинжтэй) | Аденовирүс Улаанбурханы вирүс |
| Гуурс-гуурсанцрын үрэвсэл (бронхит, бронхиолит) | RSV Иж томуугийн вирүс (3 хэвшинжтэй) | Томуугийн А вирүс |
| Уушгины үрэвсэл (пневмони) | RSV Иж томуугийн вирүс Томуугийн вирүс | Аденовирүс Улаанбурханы вирүс Салхин цэцгийн вирүс |




Томуугийн үндэсний төв 2016-09-20 11:28:32

## Риновирус (rhinovirus)

- Риновирүс нь пикорнавиридагийн овогт багтдаг. Вирүс нь бүрхүүлгүй учир гадаад орчинд тэсвэр муутай, амьдрах таатай орчин 33-35 градус. 37-оос дээш хэмд вирүсийн үржил зогсоно.
- Үүгээр риновирүсийн хамар хоолойг гэмтээх чадвартай нь тайлбарлагдана. Халдвар хамрын хөндийн салст бүрхүүлээр нэвтрэн орж эпител эс дотор үрждэг. Амьсгалын доод замыг бодвол хамрын хөндий доторхи хэм бага байдаг тул вирүсийн идэвхжил нь хэсэг газрын үрэвслийн хариу урвал үзүүлдэг.
- Халдвар нь агаар дусал, ахуйн хавьтлын замаар дамжина. Халдварын эх уурхай нь вирүс тээгч эсвэл өвчтөн.

## Риновирус (rhinovirus)

- Өвчний нууц үеийн хугацаа 1-5 дунджаар 2-3 хоног байна.
- Өвчин чичрүүдэс хүрэх, бие тавгүйрхэх, биеийн хэм 37-37.5-д хүрч, цочмог эхэлнэ. Хамар битүүрсний улмаас амьсгалахад бэрхшээлтэй болж хамрын ойр орчим, духны хэсгээр өвдөх шинж тэмдэг илэрнэ.
- Хамраас их хэмжээгээр цайвар шингэн нус гарах, хоолой хуурайших, загатнах, заримдаа өвдөх шинж тэмдэг илэрнэ. Зарим өвчтөнд бага зэрэг нүдний салст үрэвсэх, нулимс гарах, ам, эрүүний хэсэгт цэврүүт тууралт гарч болно.
- Насанд хүрэгсдэд халдвар дунджаар 7-10 хоног хөнгөн хэлбэрээр явагдах боловч хамрын ханиад 2 долоо хоног үргэлжилж болно.
- Хүүхдүүдэд биеийн хэм 38-39-д хүрч, биеийн архаг халдварын голомт идэвхжих, нянгийн халдварт өртсөний улмаас:

| | |
|---|---|
| Эрт үеийн | отит, синусит |
| Хожуу үеийн | хатгалгаа, менингит, гүйлсэн булчирхайн үрэвсэл |

## Аденовирус (adenovirus)

- Аденовирусийн овгийн ДНХ агуулсан вирусээр үүсгэгдэнэ. Энэ бүлэгт 90 орчим дэд хэвшинж байдаг.
- Амьсгалын замын салст бүрхүүл, нүдний хараа, гэдэс, булчирхайн эрхтэнүүдийг гэмтээдэг АЗЦХӨ.
- Ихэвчлэн хүүхэд, идэр насны залуучууд өртөмхий байна.
- Халдвар агаар дусал, хавьтал, өтгөн - амны (бассейн, гол, нуурын усаар дамжин) замаар дамжин халдварлана.




Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

## Аденовирүсийн халдварын сонгомол 4 шинж тэмдэг:

Нууц үе: 1-14 хоног (дунджаар 5-7 хоног)

| | |
|---|---|
| **Ринит** | хамрын салст бүрхүүл үрэвсэх, нусгайрах |
| **Фарингит** | залгиур, хөөмийн үрэвсэл – хоолой өвдөх |
| **Конъюнктивит** | нүдний салст бүрхүүл үрэвсэх – нүдний салст хавагнах улайх, нулимс гоожих |
| **Халуурах** | биеийн хэм нэмэгдэх |

*Шинж тэмдгүүд хавсарч тохиолдож болно. Үүнд:*

ринофарингит : хамрын хөндий, нармай, залгиур үрэвсэх

ринофаринготонзиллит : хамрын хөндий, залгиур, хүүхэн хэл үрэвсэх

ринофарингобронхит: хамрын хөндий, залгиур, гуурсан хоолой үрэвсэх

фарингоконъюнктивит : залгиур, нүдний салст бүрхүүлийн хамт үрэвсэх

конъюнктивит ба кератоконъюнктивит: нүдний салст ба эвэрлэг бүрхүүлийн үрэвсэл

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

# Аденовирус (adenovirus)

Ихэнх тохиолдолд хөнгөн явцтай байна.

Элбэг тохиолддог хүндрэл:

- Уушгины хатгалгаа
- Гүйлсэн булчирхайн үрэвсэл
- Хамар дайвар хөндийн үрэвсэл
- Дунд чихний үрэвсэл
- Бронх ба альвеолын хана хөөх
- Элэг, бөөр, дэлүү гэмтэх
- Бусад архаг өвчин сэдрэх

## Респиратор-синцитиаль вирус / РСВ /

- РСВ нь Парамиксовиридын бүлэгт хамаарагдах бүрхүүлгүй, дан РНХ вирус.




Вирусийн гадаргууд байрлах G, F, M уургуудын тусламжтай хучуур эсэд нэвтрэн орж репликаци явагдан дархлалын урвалыг өдөөн үрэвслийн процесс явагдана.

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ

## Респиратор-синцитиаль вирүс (РСВ)

А хэвшинж: хоруу чанар өндөртэй, амьсгалын доод замыг гэмтээнэ, ялангуяа бага насны хүүхдэд уушгины хатгалгааны гол шалтгаан болдог. РСВ-ийн халдварын үед ханиалгах, нусгайрах, хоолой өвдөх, чих өвдөх, халуурах зэрэг эмнэлзүйн шинж тэмдгүүд илрэх ба амьсгалын доод замыг өвчлүүлэн гуурсанцарын үрэвсэл, уушгины хатгалгаа, багтраа зэрэг хүндрэлийг үүсгэх эрсдэлтэй байна.

В хэвшинж: хүндрэл бага, эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг балархай хэлбэрээр явагддаг.

## Коронавирүсийн халдвар (HCoV)




- **Сурфактант гэмтсэнээс альвеолд коллапс болж, хийн солилцоо алдагдана.**
- **Хүнд үед уушги цочмог гэмтэх хамшинж илэрч, амьсгалын хүнд дутагдал илэрнэ.**
- **Вирүс-нянгийн гаралтай “атипичная пневмония” үүсгэнэ.**
- **Уушгины эдэд фиброзон өөрчлөлт үүсгэх эрсдэлтэй тул эмнэлгээс гарсаны дараа өвчтөний биеийн байдал муудах шалтгаан болдог байна.**

## Эмгэг жам

- Вирус амьсгалын замын эсүүдийн дотор орж үржих үе
- Вирус цусаар тархах үе
- Амьсгалын замын тодорхой хэсэг илүү гэмтэж үрэвсэх үе
- Нянгийн хүндрэл гарах үе:
  - амьсгалын хүнд халдвар үүсэх
  - далд халдварт шилжих үе
  - архаг байдалд шилжих
- Эдгэрэх үе: - үлдэцгүй
  - үлдэцтэй:
    - *-тухайн эрхтэн тогтолцоо*
    - *-бусад эрхтэн тогтолцоо*

## Эмнэл зүй:

**Гол шинжүүд** :

- Ханиалгах
- Амьсгаадах
- Хоолой өвдөх
- Нус гоожих
- Чих өвдөх, булагтах
- Халуурах

**Ханиалгалт**:
бөгшүүлж
цэртэй
хөхүүлж
эмзэглэж
хуурай
тагшуу
үргэлжилсэн
хуцуулж
шөнийн
өглөөний г.м

**Амьсгаадалт:**
амьсгал гаргалт саадтай
амьсгал авалт саадтай
амьсгалд туслах булчин оролцох
**Хөхрөлт:** - төвийн
- захын
**Цээж хонхолзох:**
- хүчтэй
- хүчтэй бус
- сул

# Халуурал

- **Халууны хэмжээгээр нь:**
  - 37.3-37,9 С бага зэрэг субфебриль
  - 38-38,9 С халуурал фебриль
  - 39-39,9 С өндөр халуурал гипертерми
  - 40С - ээс дээш амь насанд аюултай халуурал

**Эмнэлзүйн шинжээр нь**:

- Улаан халуурал
- Цагаан халуурал

# Халуурал

- Халдварын шалтгаант:

  Нян, вирус, эгэл биетнүүд, мөөгөнцөрөөр үүсгэгдсэн цочмог ба архаг үрэвсэлт өвчнүүдийн үед үүснэ.

- Халдварын бус шалтгаант
  - Дотор эрхтнүүдэд цус харвалт үүсэх
  - Хорт хавдарууд
  - Гэмтэл
  - Үхжилт голомтууд

    */ зүрхний шигдээс,цус харвалт г.м /*
  - Харшлын эмгэгүүд

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ

# Халууралтын муруй




| | | | | |
|---|---|---|---|---|
| **Тогтмол халуурахт** | Febris continia | Постоянная | Халууны хэмжээ өндөр зөрүү нь 1 хэмээс ихгүй | Ходоод гэдэсний үрэвсэл, уушигны хатгалгаа |
| **Сульдуулах** | Febris remittens | послабляющая | Халууны хэлбэлзэл 2-3 хэм | Вирусийн халдвар, плеврит, балнад |
| **Сэлгэх халуурахт** | Febris intermittens | Перемежающаяся | Халууны хэлбэлзэл өндөр | Идээт халдвар, сүрьеэ, хумхаа, хэрх төст үений үрэвсэл |
| **Тамирдуулах халуурахт** | Febris hectic | Изнуряющая | Халууны зөрүү 3-5 хэм | Цусан халдвар, идээт хүнд халдвар |
| **Эргэх халуурахт** | Febris recurrens | Возвратная | Хэд хоног дараалан халуураад | Дахисан балнад, лимфогранулематоз аденовирусийн халдвар |
| **Гаж халуурахт** | Febris athypica | Неправильная | Халуун өндөр, зөрүү янз бүр | Цусан халдвар |

Н.Гэндэнжамцын нэрэмжит
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ
Since 1930

## Халуун бууруулах эмүүд:

- Противовоспалительные - үрэвслийн эсрэг / Ибупрофен /
  Ибуфен,Нурофен,Ибуклина,Мига
- Обезболивающие - өвдөлт намдаах / ацетилсалициловавая кислота /
  Аспирин , Аспирин С , Цитрамон, Упсарин упса
- Жаропонижающие - халуун бууруулах / ацетоаминофен /
  Парацетомол,панадол,Тайленол,Колдакт,Терафлю .

Н.Гэндэнжамцын нэрэмжит
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ
ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ
Since 1930

## Үзлэгт анхаарах зүйл:

**Харна, сонсоно:** /хүүхэд тайван байх ёстой/

- Хүүхдийн амьсгалыг нэг хоромд тоолно
- Амьсгалахад цээж хонхолзож буйг хар
- Хяхтнаа амьсгал буйг сонс, ажигла
- Шуугиантай амьсгалахыг сонс, энэ нь багтраа юу?
- Хүүхдийн нойр өөрчлөгдөх буюу унтаарч буйг үз
- Бие халуун эсвэл хүйтэн буйг мэдэр
- Хүүхэд хэр турж эцсэнийг ажигла

**Хүүхдийн амьсгалын тоо, насны хамаарал:**

| | |
|---|---|
| • 2 сар хүртэлх нярай | 60 ба түүнээс олон |
| • 2 сараас 12 сар хүртэлх хөхүүл нас | 50 ба түүнээс олон |
| • 12 сараас 5 хүртэлх нас | 40 ба түүнээс олон |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

## Томуу ба КОВИД-19 өвчний ижил төстэй ба ялгаатай талууд.

| Ижил төстэй тал. | Нийтлэг шинж тэмдэг. | Ялгаатай тал. |
|---|---|---|
| **Томуу** ба **ковид-19** өвчин аль алиных нь үед **олон шинж тэмдэг янз бүрийн далайцтай илэрдэг**: шинж тэмдэггүйгээс эхлээд хүнд хэлбэрээр явагдана. | Халуураах эсвэл халуунтай мэт байх/жихүүдэх.<br>Ханиалгах<br>Амьсгал богиносох эсвэл амьсгалахад түвэгтэй болох<br>Ядрах,сульдах<br>Хоолой сөөнгөтөн хөндүүрлөх<br>Хамраас нус гоожих, хамар битүүрэх<br>Булчингаар өвдөх, бие хөндүүрэх<br>Толгой өвдөх<br>Заримдаа **бөөлжих, суулгах шинж** илрэх ба энэ нь **хүүхдэд илүүтэй** тохиолдоно | Томуу вирус хөнгөнөөс хүнд зэргийн өвчлөл үүсгэж болох бөгөөд дээрх нийтлэг шинж тэмдгүүд илэрнэ. Зарим тохиолдолд нас баралтанд хүргэж болно. **Томуу өвчин нь ханиад нусгайгаас ялгаатай.**<br><br>**КОВИД-19** өвчний үед томуугаас ялгаатай нь **амт** ба **үнэр мэдрэх байдал өөрчлөгдөх** ба/эсвэл **алдагдах** шинж илэрч болно**.** |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

## Өвчилсөн хүн хэр удаан вирусийн халдвар тарааж болох вэ?

| Ижил төстэй тал: |
|---|
| **Томуу** болон **КОВИД-19** өвчний аль алиных нь үед **өвчний ямар нэгэн шинж тэмдэг илрэхээс багадаа нэг хоногийн өмнөөс** эхлэн вирус тарааж эхлэх боломжтой. |
| Ялгаатай тал: |
| **КОВИД-19** өвчний үед халдварлуулах чадвар томуугийнхаас илүү удаан хугацаанд үргэлжилж болно.<br>**Томуугийн үед** ихэнх хүмүүс өвчний шинж тэмдэг илрэхээс нэг хоногийн өмнөөс эхлэн халдварлуулах боломжтой.<br>**Томуугийн үед** том хүүхэд ба насанд хүрэгсэд **өвчний эхний 3-4 хоногтоо халдвар тараах чадвар хамгийн өндөр** байдаг бөгөөд **олон тохиолдолд 7 хоног хүртэлх хугацаанд халдвар тараах** чанар хадгалагдаж болно.<br>**Нялхас** болон **дархлаа сул хүмүүс илүү удаан хугацаагаар халдвар тараах** чадвартай байж болно.<br>КОВИД-19 өвчний үед өвчилсөн хүн хэр удаан хугацаанд халдвар тарааж байгаа нь судлагдаж байна.<br>**КОВИД-19** өвчтэй хүн **шинж тэмдэг илрэхээс 2 өдрийн өмнөөс халдварлуулах боломжтой** бөгөөд **шинж тэмдэг эхэлснээс хойш багадаа 10 хоног халдвар тараах** боломж хэвээр байж болохоор байна.<br>Хэрэв **шинж тэмдэггүй** эсвэл **шинж тэмдэг арилсан** боловч **КОВИД-19 шинжилгээ эерэг гарснаас хойш багадаа 10 хоног халдвар тараах** боломжтой байж болохоор байна. |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

**Хүндрэл: Томуу болон КОВИД-19 өвчний үед**

| Ижил төстэй тал: | Ялгаатай тал: | КОВИД-19 өвчний үед үүсэх бусад хүндрэл |
|---|---|---|
| Уушгины үрэвсэл. | Томуугийн үед ихэнх хүмүүс цөөн хэд хоногийн дотор хоёр долоо хоног хүрэхгүй хугацаанд эдгэрдэг. Харин зарим тохиолдолд дээрх хүндрэлүүд үүсэх нь бий. | Уушиг, зүрх, хөл ба тархины артери венийн судсанд цусны бүлэн үүсэх. |
| Амьсгалын дутагдал. | | Олон Эрхтэн Тогтолцооны Үрэвслийн ХамШинж. |
| АЦДХШ | | |
| Үжил | | |
| Зүрхний гэмтэц \зүрхний инфаркт,цохилт\ | | |
| Олон эрхтний дутагдал. | | |
| Архаг өвчнин эмгэг сэдрэх, дордох. | | |
| Тархи,зүрх,булчингийн эд үрэвсэх. | | |
| Нянгийн хоёрдогч халдвараар хүндрэх. | | |

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

**ТТТӨ-өөр эмнэлэгт хэвтэгсдийг тусгаарлах хугацаа:**

- Өвчин эхэлснээс хойш 7 хоног.
- Эсвэл халуурал ба амьсгалын замын шинжүүд засарснаас шинжүүд засарснаас хойш 24 цаг өнгөртөл.
- Хүндэрсэн, удаан явцтай тохиолдолд өвчний цочмог үеийн эмнэлзүйн шинж засарч сайжрал илэртэл.

Жич: Дархлаа сул үед вирусийн ялгаралт илүү удаан явагдах магадлалтай, мөн тэсвэрлэг вирус үүсгэх эрсдэлтэйг анхаарах.

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

# Оношлогоо:

Өвчтэй хүүхэд

ЭАЯТ / Бүх хүүхэд /
- A
- B
- C-Cm-Cn
- Д

ХӨЦМ / 0- 5 нас /
- -АЕШ
- -Гол шинж
- - Бусад өвчин үнэл

ОНТ-ХӨЦМ / 0-5 нас /
- ЭХЭМДэвтэр / ЭМС-ын 2013 он 450 /

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ Since 1930

# Эмчилгээ

- **Үүсгэгчийн, шалтгааны эсрэг вирүсийн эсрэг өвөрмөц, антибиотик, дархлаа дэмжих эмчилгээ)**
- **Асаргаа, сувилгаа:**
  - Шингэн сайн уулгах, сайн хооллох, хүндэрч байгаа эсэхийг хянах - Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / ягаан дэвтэр /
- **Шинж тэмдгийн: / ХӨЦМ /**
  - Ханиалга дарах
  - Халуун бууруулах
  - Шуугиант амьсгалыг намжаах
  - Амьсгал бачуурлыг намжаах
  - Өвдөлт намдаах
- **Эмгэг жамын:** / ***Амьсгалын замын хүнд халдвар - ЭМС-ын 358 тоот тушаал 2.1.2 /***
  - хордлого тайлах
  - эрхтнүүдийн хямарсан үйл ажиллагааг засан сэргээх
  - бүтцийн эмгэг өөрчлөлтийг зогсоох
  - биеийн дархлал урвалыг идэвхижүүлэх
  - ерөнхий эсэргүүцлийг сайжруулах
  - халдварлалыг аль болох эрт зогсоох

Эмчилгээний удирдамж:

**ХӨЦМ:** **2000 он хүүхдийн өвчний цогц менежемент**
**2022 онд шинэчлэгдсэн \6 удаа**

**ЭАЯТ:** **2020 онд шинэчлэгдсэн**

**ОНТ- ХӨЦМ:** **2010 он**

**Томуу, томуу төст өвчний тархалтын үед баримтлах оношлогоо эмчилгээний заавар зөвлөмж:**
**ЭХЭМҮТ:**
**2019 – 2020 оны томуугйн улиралд баримтлах эмнэлзүйн удирдамж**
**2020-2021 оны томуугийн улиралд баримтлах эмнэлзүйн удирдамж**
**2021-2022 он. Томуу, Томуу төст өвчний тархалтын үед баримтлах оношлогоо эмчилгээний долоодугаар удирдамж /нэмэлт/**

# Томуу Томуу Төст Өвчнөөс сэргийлэх үндсэн аргууд:

1. Нийтлэг арга хэмжээ.
2. Улирлын томуугийн эрсэг вакцинжуулалт.
3. Эмийн сэргийлэлт (цөөн тохиолдолд, онцгой заалтаар)

## Хяналт:

- Гэрээр эмчилнэ.
- ЭХЭМД –ашиглан гэр бүл асран хамгаалагч нарын дадал хэвшлийг өөрчлөх зөвлөгөө
- Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө
- Давтан үзлэгт хамруулж эмчилгээг гүйцэд хийлгэхийг зөвлөнө.
- Хүүхдэд илэрч байгаа суурь эмгэгийг эмчилж, дархлаажуулалтын байдалд үнэлгээ хийж шаардлагатай бол нэмэлт вакцинд хамруулж,хооллолтын бэрхшээлийг засаж өвчинд өртөмтгий байдлыг багасгаж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ЭМТ,ӨЭМТ-ийн ЭМА-ын үндсэн үүрэг юм.

**Анхаарал хандуулсанд баярлалаа.**